| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,172,500.00 | 1,172,500.00 | 1,080,500.00 | 1,080,500.00 | - | 100.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - | - | 315,520.48 | (315,520.48) | - |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,332,156.92 | - | 315,520.48 | (315,520.48) | - |
| **81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах** | | **1,200,000.00** | **1,200,000.00** | **1,100,000.00** | **1,150,000.00** | **(50,000.00)** | **104.55** |
| 12 | Татварын бус орлого | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,025,000.00 | 1,025,000.00 | - | 100.00 |
| 123 | Татаас санхүүжилтийн орлого | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,025,000.00 | 1,025,000.00 | - | 100.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,025,000.00 | 1,025,000.00 | - | 100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,100,000.00 | 1,150,000.00 | (50,000.00) | 104.54 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,100,000.00 | 1,100,000.00 | - | 100.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,100,000.00 | 1,100,000.00 | - | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,100,000.00 | 1,100,000.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,100,000.00 | 1,100,000.00 | - | 100.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - | - | 50,000.00 | (50,000.00) | - |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - | - | 50,000.00 | (50,000.00) | - |
| **12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - | - | - | - | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлан он |
|---|---|---|---|
| **11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | - | - |
| **71801 - Сургуулийн өмнөх боловсрол** | | - | **1,490,836.00** |
| **81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх** | | - | **1,490,836.00** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 1,490,836.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 1,490,836.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 1,490,836.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 453,136.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 453,136.00 |
| 2105 | Нормативт зардал | - | 200,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 200,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 837,700.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 837,700.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 1,490,836.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 1,490,836.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн | - | 653,136.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт | - | 837,700.00 |
| **12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - | - |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Есөнзүйл сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу дээр зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.02.17-наас 2022.02.19–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.15-ний өдрийн 01 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино." гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь "Хүүхдийн хэрэгцээ сонирхлыг эрхэмлэн эрүүл, бүтээлч, таатай орчинд тоглох үйлээр нь дамжуулан Зөв монгол хүүхдийг хамтдаа хөгжүүлнэ. гэсэн зорилгыг тодорхойлж, тухайн онд 3 зорилт дэвшүүлжээ.

- Байгууллагын болон удирдлагын менежментийг боловсронгуй болгон, үйл ажиллагааны тогтвортой хөгжил, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх
- Сургалтын арга технологи, менежментийг сайжруулан, сургалт үйл ажиллагааны чанарт технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх
- Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны стандартыг хэрэгжүүлэх, эрүүл аюулгүй сургалтын орчныг бүрдүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Есөнзүйл сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан

төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнзүйл сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 229.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнзүйл сумын цэцэрлэгийн 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 69.7 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 1.2 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 68.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр авчээ. Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн 61.4 сая төгрөг нь аймгийн хөрөнгө оруулалтаар засвар хийснийг сайжруулалтаар авчээ. 7.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэ тогтоож ашиглахаар бүртгэсэн байна. Тайлант онд 9.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталжээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 26.8 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр бэлтгэж 21.7 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 0.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 199.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 22.4 сая төгрөг батлагдаж, 222.2 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс төсвөөс авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 1.5 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

## 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Есөнзүйл сумын цэцэрлэг нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 222.2 сая төгрөгийн 150 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 222.2 сая төгрөгийн 149 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч ажиллалаа.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар бараа материалын тайлан гаргаагүй, тооллого хийгээгүй, ажилчдад цалин нэмэгдэл илүү олгосон зэрэг 212.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлага, актын биелэлтийг 2021.05.05-ны №10 дугаар бүхийн албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлсэн байна.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар хүнсний материалын үлдэгдлээсээ зарцуулж, энэ хичээлийн жилийг дуустал хугацаанд хоолны төсвөөс худалдан авалт хийхгүй байж, тэр хэмжээгээр зардал хэмнэгдэнэ гэж үзэж 15.9 сая төгрөгөөр санхүүгийн үр өгөөжөөр тооцож, хүлээн зөвшөөрүүлсэн.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 0.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар.**

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны сайтад 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

**Зөвлөмж-1**. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх **1** зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 05 дугаар сарын 30-ны** өдрийн дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Есөнзүйл сумын цэцэрлэг | 4 | 4.6 | | | 1 | 4.4 | 2 | 0.2 | 1 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 21 өдөр Дугаар ӨВА-2022/1Н/НА-СТА-ТШЗ/А1560349/116 Арвайхээр

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд норм зөөлөн эдлэлийн зардлаас 200.0 мянган төгрөгийн ажилчдын хувцас бэлтгэсэн /т/х №132/ зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; "гэсэн заалт, Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д "... автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах , фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээр дурдсан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан тухай биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын цэцэрлэгийн эрхлэгч Б.Энхжаргал, нягтлан бодогч Б.Азсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 21 өдөр Дугаар ОВА-2022/14/НА-СТА-ТШЗ/А15603419/115 Арвайхээр

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнсний материал 2021 оны эхэнд 12473.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байхад 14661.7 мянган төгрөгийн хүнс нэмж орлого аваад 11317.9 мянган төгрөгийг хоолонд зарцуулж оны эцсээр 15938.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь хүүхдийн хоолны зардлыг ямар ч тооцоо судалгаагүй, хяналтгүй зарцуулж иржээ. Хүнсний үлдэгдэл ихээр нөөцлөгдөж байгаа нь хүнсний чанар байдал өөрчлөгдөх, хадгалалтын хугацаа дуусаж хүнсний аюулгүй байдал алдагдах, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.4-д заасан “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, 2022 оны 02 дугаар сараас эхлэн энэ хичээлийн жилийг дуустал хугацаанд хоолны төсвөөс худалдан авалт хийхгүй байх.
2. Үлдэгдлээр байгаа хүнсний нөөцдөө тулгуурлан 1 хүүхдэд олгох хүүхдийн хоолны зардал, норм нормативт хэмжээг баримталж үлдэгдэл хүнсийг зарцуулж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан тухай биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын цэцэрлэгийн эрхлэгч Б.Энхжаргал, нягтлан бодогч Б.Азсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АКТ

2022 оны 02 сарын 21 өдөр Дугаар ӨВА-2022/14/НА-СТА-ТШЗ/А1560349/10 Арвайхээр

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар 2019 онд гэрээгээр мах нийлүүлж байсан "Дэлгэрэх булгийн хишиг" хоршоонд мөнгөө урьдчилж шилжүүлэн махаа цувруулан авч байсан ч цар тахалтай холбоотой сургалтын үйл ажиллагаа зогсож, түүнээс хойш бага багаар нийлүүлсэн боловч өнөөг хүртэл үлдэгдэл 4390.1 мянган төгрөгийн махаа нийлүүлээгүй байна. Мөнгийг нь шилжүүлээд махаа бүрэн аваагүй байж хүнсний тайланд орлого авсан зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5-д заасан "бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх нийлүүлэгдээгүй махны 4390.1 мянган төгрөгийг "Дэлгэрэх булгийн хишиг" хоршоогоор буцаан төлүүлж Өвөрхангай аймгийн Төрийн сан дахь Өв.Орон нутгийн ерөнхий орлого 100100000910 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Есөнзүйл сумын цэцэрлэгийн эрхлэгч Б.Энхжаргал, нягтлан бодогч Б.Азсүрэн, нярав С.Долгормаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

**Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт**

**Аудитын нэр:** Санхүүгийн тайлангийн аудит **Аудитын код:** ӨВА-2022/14/НА-СТА-ТШ3

**Байгууллагын нэр:** Есөнзүйл сумын цэцэрлэг

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /сая/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын Албан тушаал | Шалгагдагч байгууллагын Овог нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Урсгал зардал | 2019 онд гэрээгээр мах нийлүүлж байсан "Дэлгэрэх булгийн хишиг" хоршоонд мөнгөө урьдчилж шилжүүлэн махаа суваргаж авч байсан ч цар тахалтай холбоотой үйл ажиллагаа зогсож, үлдэгдэл 4390.1 мянган төгрөгийн махаа одоог хүртэл аваагүй 2 жил болсон байна. Мөнгийг нь шилжүүлээд махаа аваагүй байж хүнсний тайланд орлого авсан зөрчил илэрлээ. | 4.4 | Акт тогтоох | Санал байхгүй. | Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | Аймгийн төсвийн орлогын 100100000910 тоот дансанд 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор төвлөрүүлэх | Дарга, Нягтлан бодогч | Б.Энхжаргал, Б.Азсүрэн |
| | Урсгал зардал | Хүүхдийн хоолны үлдэгдэл оны эхэнд 12473.1 мянган төгрөг байхад 14661.7 мянган төгрөгийн хүнс нэмж орлого аваад 11317.9 мянган төгрөгийг хоолонд зарцуулж 15938.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь хүүхдийн хоолны зардлыг үр ашиггүй, хяналтгүй зарцуулж иржээ. Хүнсний үлдэгдэл ихээр нөөцлөгдөж байгаа нь хүнсний чанар байдал, хадгалалтын хугацаа дууссан хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй байна. | 0 | Албан шаардлага өгөх | Санал байхгүй. | Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | Албан шаардлага өгөх | Дарга, Нягтлан бодогч | Б.Энхжаргал, Б.Азсүрэн |
| 2 | Урсгал зардал | Багш ажилтнуудад 200.0 мянган төгрөгийн хувцас бэлтгэсэн. | 0.2 | Албан шаардлага өгөх | Санал байхгүй. | Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д "... автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, албан томилолт, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" | Албан шаардлага өгөх | Дарга, Нягтлан бодогч | Б.Энхжаргал, Б.Азсүрэн |
| 2 | Шилэн данс | Шилэн дансны сайтад 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. | | Зөвлөмж өгөх | Санал байхгүй. | Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. | **Зөвлөмж-1.** Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах. | Дарга, Нягтлан бодогч | Б.Энхжаргал, Б.Азсүрэн |
| | | | 4.6 | | | | | | |

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ЭНХЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ Б.АЗСҮРЭН